# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 20 өдөр　　　　Дугаар 03　　　　Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг түр орлох**

**Этгээд томилох тухай**

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.5, 9.2.9 дэх заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.1, 2.5.1 дах заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

4. Компанийн ТУЗ-ийн гишүүн Б.Золжаргалын өөрийн хүсэлтийг харгалзан үзэж 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсүгэй.

5. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны 1 сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоол болон Цалин урамшууллын хорооны 2023 оны 1 сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар нөхөн сонгууль болох хүртэл ТУЗ-ийн гишүүн Б.Золжаргалыг түр орлох этгээдээр Монгол Улсын иргэн Пунцагноров овогтой Чинзоригийг томилсугай.

6. Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн дагуу ТУЗ-ийн гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол улсын иргэн Пунцагноров овогтой Чинзориг нь Компанийн ТУЗ-ийн гишүүний эрхийг 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн нөхөн сонгууль явагдах хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.

7. ТУЗ-ийн гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол Улсын иргэн Пунцагноров овогтой Чинзориг-д Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох журмуудыг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

8. ТУЗ-ийн гишүүнийг түр орлох этгээд томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА　　　　Ч.ЧИНЗОРИГ

УЛААНБААТАР ХОТ
ТАНДЭМ ИНВЭСТ
ББСБ
ХК
ШТ78176 9020020771 2013916